



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/73

Есөнбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.2 дэх хэсэг, Засгийн газрын 2025 оны 259 дүгээр "Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай" тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн аж ахуйн нэгж, байгууллагын ээлжит тооллогыг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, комиссын ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Аймгийн аж ахуйн нэгж, байгууллагын тооллогыг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Статистикийн хэлтэс (Д.Тунгалаг)-т, тооллогыг заавар журмын дагуу чанартай зохион байгуулж, тооллогын ажлын тайланг илтгэх хуудсаар тайлагнаж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тооллогын комисс (М.Алтангэрэл)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
08 дугаар сарын 08 ны өдрийн 11 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН
ТООЛЛОГЫН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:	М.Алтангэрэл	(Аймгийн Засаг даргын орлогч)
Орлогч дарга:	Ш.Эрдэнэбат	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд:	Я.Жаргалцэцэг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга)
	Л.Хаш-Эрдэнэ	(Аймгийн ЗДТГ-н Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
	Э.Баттайван	(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)
	Н.Энхтуяа	(Татварын газрын дарга)
	Г.Чүлтэмжамц	(Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)
	Л.Энжаргал	(Нийгмийн даатгалын газрын дарга)
	Д.Энхцэцэг	(Боловсролын газрын дарга)
	Б.Тогтохбаяр	(Статистикийн хэлтсийн (Бизнес регистрийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	Д.Тунгалаг	(Статистикийн хэлтсийн дарга)

Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 05-ны өдрийн АЗС дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

**АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫН
КОМИССЫН УДИРДАМЖ**

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1. Статистикийн тухай хуулийн 7.1.3, 20.2 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 259 дүгээр "Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай" тогтоолыг үндэслэн аж ахуйн нэгжийн тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулахтай холбогдуулан энэхүү удирдамжид заасны дагуу Үндэсний статистикийн хороотой хамтран харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тооллогын үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.

Хоёр. Ерөнхий үйл ажиллагаа:

2.1. Үндэсний статистикийн хороо, тооллогын улсын комиссоос өгсөн чиг үүрэг удирдамжийн дагуу тооллогын холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх

2.2. Тооллогын комиссыг байгуулж, хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд Үндэсний статистикийн хороотой хамтран ажиллах, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлах, хэрэгжилтийг хангах

2.3. Тооллогын үйл ажиллагааны явц, төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар Үндэсний статистикийн хороо болон Тооллогын улсын комисст тухай бүр тайлагнах

Гурав. Тусгайлсан үйл ажиллагаа:

3.1. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тооллогын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, танилцуулгыг зохион байгуулах

3.2. Үндэсний статистикийн хорооноос боловсруулан хүргүүлсэн тооллогын сурталчилгаа мэдээллийн материалыг олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулах

3.3. Мэдээлэл цуглуулагч, тооллогын комиссын гишүүдийг ажиллах орчин нөхцөлөөр хангах

3.4. Тооллогын үйл ажиллагааны явцад тулгарч буй хүндрэл, бэрхшээлийн талаар Үндэсний статистикийн хороо болон Тооллогын улсын комисст тухай бүр мэдээлж, холбогдох арга хэмжээ авч ажиллах

3.5. Тооллоготой холбоотой авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг боловсруулж, Үндэсний статистикийн хороо болон Тооллогын комисст тайлагнах